

ТЭНХИМИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫГ ТӨЛӨВЛӨХ, ХЭМЖЭЭСЖҮҮЛЭХ НЬ


Б.Пүрэв-Очир

МУБИС нь өнгөрсөн хичээлийн жилийнхээ үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, 2008-2009 оны сургалт-эрдэм шинжилгээний жилийнхээ үйл ажиллагааны зорилтоо дэвшүүлэн, ажлаа төлөвлөн ажиллаж байна. Эрдэм шинжилгээний хувьд:

- Тэнхим, төв, түүний багш — эрдэмтэд, баг-хамтлагийн судалгаа – боловсруулалтын ажлыг онцлогтойгоо тохируулан хэмжээсжүүлж, “Ажлын норм, түүнийг тооцох журам”-тай уялдуулж, жил, хагас жилээр оновчтой төлөвлөж, гүйцэтгэх;

- Тус их сургуулийн шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл, шийдвэрлэж явах судалгааны сэдвүүдийн хэрэгжилт, үр дүнд шинжилгээ үнэлгээ хийснээр, судалгаа – сургалтыг оновчтой хослуулан, магистрант, докторантын оролцоог нэмэгдүүлж, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх;

- Мэргэжлийн тэнхимүүдийн эрдэм шинжилгээний их семинарын үр өгөөжийг дээшлүүлэн, “Их сургуулийн судалгаа боловсруулалтын ажлыг дэмжих зорилтот хөтөлбөр”-ийн /2007-2015 он хүрээнд лаборатори, төвүүдийг шинэчлэхэд ахиц гаргах гэсэн зорилт дэвшүүлсэн бөгөөд энэхүү зорилтоо хэрэгжүүлэхийн тулд нэгжүүдийн үйл ажиллагаанд голлон анхаарч ажиллаж байна. Эхний зорилтыг хэрэгжүүлэхийн тулд бүрэлдэхүүний сургууль, тэнхимүүдээс саналыг нь авч, сургалт семинар зохион байгууллаа. Энд хамгийн чухал нь Профессор-багшийн судалгаа боловсруулалтын цагийг хэрхэн яаж төлөвлөх, хэмжээсжүүлэх вэ? гэсэн асуудал байгаа бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах зүйлүүдийг анхааралтай авч үзэх шаардлагатай байна.



Профессор-багш нь нийт 1680 цагийн ажлын нормтой ба үүний 560 нь эрдэм шинжилгээний цаг байхаар төлөвлөх учиртай болж байна. Гэхдээ энэ нь сургалт аргазүй хоёроосоо салангид зүйл биш, хоорондоо уялдаа холбоотой, бие биеэсээ урган гарч байх ёстой.

Сургалт	Эрдэм шинжилгээ	Аргазүй
	560 цаг	

Профессор багш нарын ажлын норм, цагийн төлөвлөлтийг оновчтой болгох үүднээс бүрэлдэхүүн сургууль, тэнхимүүдийн саналыг авсан бөгөөд ерөнхийд нь нэгтгэн үзвэл дараах чиг хандлагатай байна. Үүнд:

- Багш нарын гүйцэтгэх ажлын цагийг нарийвчлах нь зүйтэй. Тухайлбал, уншсан ном зохиолын хэвлэлийн хуудаснаас хамаарч цаг тооцох г.м.
- Зарим нь цөөн гүйцэтгэх ажил дээр багц цаг тооцож болох талтай.
- Хамгийн чухал гэсэн зүйлдээ их цаг төлөвлөх. Тухайлбал, шинжлэх ухааны доктор хамгаалбал 700 цаг г.м.
- Өөрийн сургуулийн онцлогт тохируулах нь зүйтэй.
- Зэрэглэл харгалзан, цагийг ялгавартай тогтоох. Жишээ нь 420-500 цаг гэсэн ерөнхий санал байгаа ба үзүүлэлт тус бүрээр нь авч үзвэл,
- Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээлд 500-700 хүртэл цаг
- Боловсролын докторын зэрэг хамгаалсан бүтээлд 200-300-350-400 хүртэл цаг
- Магистрын зэрэг хамгаалсан бүтээлд 100 - 200 хүртэл цаг
- Эрдэм шинжилгээний нээлт хийх, шинэ технологи боловсруулж эрх авсан бол 500-700 хүртэл цаг
- Гадаадын их, дээд сургуулийн болон эрдэм шинжилгээний байгууллагын тогтмол хэвлэлд хэвлэгдсэн өгүүлэл бүрт 150 – 300 — 500 хүртэл цаг

• МУБИС, МУИС болон төрийн өмчийн бусад их сургуулиуд, ШУА-ийн салбарын, хүрээлэнгүүдийн эрдэм шинжилгээний цуврал, бичигт хэвлэгдсэн өгүүлэл бүрт 100-200 хүртэл цаг

• Олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл бүрт 150-200-300 хүртэл цаг

• Улсын чанартай эрдэм шинжилгээ, онол практикийн бага хуралд хэлэлцүүлсэн илтгэл бүрт 100-200 хүртэл цаг

• МУБИС-ийн профессор-багш нарын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл бүрт 50-100 хүртэл цаг

• Олон улсын болон Монгол улсын хэмжээний сургалт-семинар, эрдэм шинжилгээний хурлын зохион байгуулж, удирдсан бол 30-100-150 хүртэл цаг

• Сургалт – судалгааг оновчтой хослуулахад дэвшилтэт технологи боловсруулсан, гадаад орны дэвшилтэт технологи дамжуулсан, нутагшуулсан бол 40 – 50 - 150 - 300 - 500 хүртэл цаг

• Оюуны өмчийн бүтээлээ бүртгүүлж, мэдээллийн санд оруулсан ажил бүрт 50-100 -150 - 300 хүртэл цаг

• Шинжлэх ухаан–технологийн тэргүүлэх чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалт татсан, грант олж авсан бол 300 – 500 хүртэл цаг

• Дүрслэх урлаг, дизайны бүтээлд 200 хүртэл цаг

• Инновацийн бүтээгдэхүүний стандартад нийцсэн сертификат авсан бол 100 - 500 хүртэл цаг

• Эрдэм шинжилгээ, туршилт үйлдвэрлэлийн баг - хамтлаг удирдахад 100 - 200 - 300 хүртэл цаг

• Оюутан, магистрант, докторантын эрдэм шинжилгээний ажил удирдсан, уралдаан тэмцээнд оролцуулсан бол 20 - 100 хүртэл цаг

- Сургалт семинар, эрдэм шинжилгээний хуралд оролцоход 10 - 25 хүртэл цаг
- Нэг сэдэвт бүтээл бичиж, хэвлүүлэхэд 350 хүртэл цаг

- Магистрант, докторантын ажилд зөвлөгөө өгөхөд 20 – 64 хүртэл цаг тооцох гэх мэт зүйл байна. Эдгээр саналыг багцалж, дараах байдлаар нэгтгэн дүгнэж болмоор байна.

Профессор – багшийн судалгаа - боловсруулалтын 560 цагийг хэрхэн яаж төлөвлөх, хэмжээсжүүлэх вэ?



Эцэст нь дүгнэн хэлэхэд, **Профессор - багшийн судалгаа боловсруулалтын 560 цагийг төлөвлөх, хэмжээсжүүлэхэд юуг харгалзах вэ?**

- Тэнхим бүр өөрийн онцлогтоо тохируулна. Тухайлбал, Дүрслэх урлагийн тэнхимийн багш нарын цагийн нормын үзүүлэлт, Монгол хэл шинжлэлийн тэнхимийнхээс өөр байх жишээтэй.
- Зэрэглэлийг харгалзана. /Өгүүлэл бичихэд доктор (Sc.D), дагалдан багшийн зарцуулах цаг өөр байхаар... Эрдэм шинжилгээ (судалгаа боловсруулалтын нэршлүүд)-д хамаарах зүйлийг (ажлын багцуудыг) хэрхэн тогтоож тусгах вэ? Жишээ нь: суурь ба хавсарга судалгааны төсөл, нэг сэдэвт зохиол, сурах бичиг, урлагийн бүтээл гэх мэт
- Хэний цагийг төлөвлөн, хэмжээсжүүлж байгаа нь ялгаатай байж болно. Жишээ нь: Залуу багш – судлаач хэнийг дагаж байгаа, хэн хэнтэй хамтарч байгаа, гадаадын эрдэмтэнтэй хамтарсан эсэх, тухайн судалгааны ажлыг багаар хийсэн эсэх гэх мэт.

Энэхүү төлөвлөлт, хэмжээсний үр дүнд эрдэм шинжилгээний ажлын чанар, үнэлэмж сайжирч, түүнийг зөв урамшуулахад нөлөөлөх юм.